

**ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангуудын эх үүсвэрийг Ашигт малтмалын тухай болон Цөмийн энергийн тухай хуульд зөрчилтэй байдлаар тусгасан нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан Баялгийн санд төвлөрүүлэх эх үүсвэрийг бууруулахаас гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т заасан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш, шударга хүртээх зарчимд нийцэхгүй байна гэж үзэж, хууль хоорондын уялдааг хангаж, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор уг хуулийн төслүүдийг боловсруулжээ.

Хуулийн төслүүдийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зүйлийг хүчингүй болгох нь хуулийн бусад зохицуулалтад хэрхэн нөлөөлөх, хууль батлагдсанаар орон нутгийн хөгжлийн санд үзүүлэх нөлөөлөл болон борлуулалтын үр ашгийн тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг цаашид бизнесийн зарчмыг анхаарах шаардлагатай байгаа талаар болон ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн доод хэмжээг тогтоох асуудлыг судалж үзсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар татвар хураамж бүрдүүлэлтэд ямар ахиц дэвшил гарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчим болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр нэмэгдсэнээр орон нутагт бий болох үр өгөөжийн талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд мөн Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд эдийн засгийн үр өгөөжийн тооцооллын талаар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Р.СЭДДОРЖ

